

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан**

Аудитын код: ХӨА-2026/198/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс 7038 3793, Цахим шуудан khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/182
танай _____-ны № _____-г

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА О.МӨНГӨНТУЯА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 2,900.9 мянган төгрөгийн санхүүжилтийн авлагатай, ажиллагсад 7,826.3 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшууллын өглөг үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 92.2 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчлийг илрүүлж залруулагдаагүй алдаа ба нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 92.2 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж, хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага хүргүүлэв.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 92.9 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>170,749,840.75</u>	<u>94,339,886.85</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	29.74	168176.44
312	Банканд байгаа бэлэн мөнгө	29.74	168176.44
3121	Төгрөг	29.74	168176.44
31211	Төрийн сангийн харилцах	29.74	168176.44
33	АВЛАГА	85,070,777.75	7,853,808.95
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		4952917.38
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	85,070,777.75	2,900,891.57
35	БАРАА МАТЕРИАЛ	85,679,033.26	86,317,901.46
351	Түүхий эд материал	33,985,796.51	26,870,196.94
35130	Эм боох материал	33,985,796.51	26,870,196.94
354	Хангамжийн материал	51,693,236.75	59,447,704.52
35410	Бичиг хэргийн материал	85,000.00	165,000.00
35420	Аж ахуйн материал	12,243,029.00	18,418,029.00
35440	Түлш, шатах тослох материал	7,000,000.00	9,800,000.00
35460	Хүнсний материал	895,750.00	2,051,345.00
35470	Бусад хангамжийн материал	31,469,457.75	29,013,330.52
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>525,441,380.04</u>	<u>471,125,523.16</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	525,441,380.04	471,125,523.16
392	Биет хөрөнгө	511,857,380.16	457,717,523.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	235,267,390.00	235,267,390.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-40,183,353.20	-45,994,699.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	217,319,366.47	222,456,866.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,079,285.25	-36,881,372.49
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	164,725,796.69	168,725,796.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	-79,500,909.86	-111,238,350.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,549,000.00	41,634,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,240,624.69	-16,252,107.95
393	Биет бус хөрөнгө	13,583,999.88	13,407,999.84
39301	Программ хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-528,000.12	-704,000.16
39303	Бусад биет бус хөрөнгө	13,232,000.00	13,232,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>696,191,220.79</u>	<u>565,465,410.01</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>34,876,365.44</u>	<u>9,512,801.33</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	34,876,365.44	9,512,801.33
413	Өглөг	34,876,365.44	9,512,801.33
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,323,806.94	8,952,801.33
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	19,104,058.50	560,000.00
4136	Бусад өглөг	3,448,500.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,448,500.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>661,314,855.35</u>	<u>555,952,608.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	661,314,855.35	555,952,608.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	333,916,115.00	333,916,115.00
51101	Өмч: - төрийн	333,916,115.00	333,916,115.00
512	Хуримтлагдсан үр дүн	257,065,995.22	151,703,748.55
51210	Өмнөх үеийн үр дүн	349,947.08	257,065,995.22
51220	Тайлант үеийн үр дүн	256,716,048.14	-105,362,246.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	70,332,745.13	70,332,745.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>696,191,220.79</u>	<u>565,465,410.01</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,361,178,718.87	1,284,340,485.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	311,853,929.13	113,127,717.93
120	Нийтлэг татварын бус орлого	311,853,929.13	113,127,717.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,368,000.00	91,825,935.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,368,000.00	91,825,935.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	26,041,777.26	16,164,282.93
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	242,444,151.87	5,137,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,049,324,789.74	1,171,212,767.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,896,800.00	31,366,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,896,800.00	31,366,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,010,427,989.74	1,139,846,467.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,010,427,989.74	1,139,846,467.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,104,462,670.73	1,389,702,732.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,104,462,670.73	1,389,702,732.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,060,759,450.19	1,300,765,954.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	748,608,939.54	894,968,644.03
210101	Үндсэн цалин	430,502,493.44	476,496,299.64
210102	Нэмэгдэл	252,640,711.10	312,286,920.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,552,000.00	31,020,000.00
210104	Урамшуулал	46,913,735.00	75,165,424.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,620,152.78	108,861,770.28
210201	Тэтгэврийн даатгал	62,113,783.09	75,384,855.26
210202	Тэтгэмжийн даатгал	7,475,744.90	8,871,320.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,543,548.90	6,637,727.55
210204	Ажилгүйдлийн даатгал	3,092,796.59	3,593,573.32
210205	Эрүүл мэндийн даатгал	12,394,279.30	14,374,293.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,630,604.46	24,220,009.11
210301	Гэрэл, цахилгаан	4,220,604.46	5,320,009.11
210302	Түлш, халаалт	32,410,000.00	18,900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,395,948.76	37,557,214.20
210401	Бичиг хэрэг	1,698,280.00	4,392,270.00
210402	Тээвэр, шатахуун	21,453,440.00	17,290,035.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,499,178.76	2,820,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,143,650.00	3,253,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	90,000.00	1,975,471.00
210408	Бараа материал акталсны зардал	1,511,400.00	7,826,337.70
2105	Нормативт зардал	84,055,692.95	106,594,639.53
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,353,215.95	92,097,484.53
210502	Хоол, хүнс	14,077,477.00	14,497,155.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,625,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,490,975.00	25,945,200.00
210604	Урсгал засвар	3,490,975.00	25,945,200.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	3,056,600.00
210702	Дотоод албан томилолт	0.00	3,056,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,231,000.00	19,621,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,433,000.00	17,397,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	55,000.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,810.00	122,710.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,150.00	00.00
210807	Газрын төлбөр	35,040.00	47,940.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,575,000.00	836,570.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,726,136.70	79,940,356.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,302,514.00	11,402,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,423,622.70	68,538,356.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,703,220.54	88,936,778.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,668,000.00	88,890,487.18
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		39,192,487.18
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,368,000.00	49,698,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,220.54	46,290.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,220.54	46,290.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	256,716,048.14	-105,362,246.67
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	256,716,048.14	-105,362,246.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,027,550,014.99	1,345,208,588.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,368,000.00	91,825,935.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,368,000.00	91,825,935.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,368,000.00	91,825,935.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,368,000.00	91,825,935.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	984,182,014.99	1,253,382,653.68
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,896,800.00	31,366,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,896,800.00	31,366,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	945,285,214.99	1,222,016,353.68
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	945,285,214.99	1,222,016,353.68
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,029,302,214.44	1,335,955,441.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,029,302,214.44	1,335,955,441.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	985,598,993.90	1,247,018,663.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	730,962,092.68	891,939,173.30
210101	Үндсэн цалин	409,972,484.49	471,605,252.79
210102	Нэмэгдэл	250,875,031.42	290,914,488.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,333,000.00	29,280,000.00
210104	Урамшуулал	47,781,576.77	100,139,432.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,063,400.00	120,215,164.00
210201	Тэтгэврийн даатгал	65,443,100.00	89,052,564.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,405,100.00	7,791,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,702,500.00	3,895,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,702,500.00	3,895,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,810,200.00	15,581,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,370,604.46	27,020,009.11
210301	Гэрэл, цахилгаан	4,220,604.46	5,320,009.11
210302	Түлш, халаалт	31,150,000.00	21,700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,365,319.00	32,086,805.50
210401	Бичиг хэрэг	1,444,580.00	4,360,270.00
210402	Тээвэр, шатахуун	21,151,440.00	17,290,035.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	2,820,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,284,299.00	4,270,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	285,000.00	3,345,600.00
2105	Нормативт зардал	66,593,710.00	107,192,092.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,796,100.00	86,594,742.00
210502	Хоол, хүнс	14,172,610.00	17,235,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,625,000.00	3,361,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,425,975.00	30,248,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	935,000.00	400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0.00	3,903,600.00

210604	Урсгал засвар	3,490,975.00	25,945,200.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	2,496,600.00
210702	Дотоод албан томилолт	0.00	2,496,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,548,878.76	20,502,020.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,817,178.76	17,846,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	55,000.00	55,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,000.00	70,000.00
210807	Газрын төлбөр	30,000.00	30,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,508,700.00	1,268,570.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,269,014.00	15,318,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,269,014.00	15,318,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,703,220.54	88,936,778.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,668,000.00	88,890,487.18
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	39,192,487.18
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	43,368,000.00	49,698,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,220.54	46,290.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,220.54	46,290.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,752,199.45	9,253,146.70
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	0.00	9,085,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	9,085,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	9,085,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	9,085,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-9,085,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-1,752,199.45	168,146.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,752,229.19	29.74
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29.74	168,176.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	333,916,115.00	70,332,745.13	349,947.08	404,598,807.21
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	256,716,048.14	256,716,048.14
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	333,916,115.00	70,332,745.13	257,065,995.22	661,314,855.35
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-105,362,246.67	-105,362,246.67
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	333,916,115.00	70,332,745.13	-151,703,748.55	555,952,608.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	төгрөгөөр	
				Зөрүү	хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,401,780,300.00	1,313,842,288.68	87,938,011.32	93.7
12	Татварын бус орлого	1,401,780,300.00	1,313,842,288.68	87,938,011.32	93.7
120	Нийтлэг татварын бус орлого	151,880,000.00	91,825,935.00	60,054,065.00	60.5
12004	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	151,880,000.00	91,825,935.00	60,054,065.00	60.5
122	Тусламжийн орлого	1,249,900,300.00	1,222,016,354.00	27,883,946.32	97.8

122001	Хандив тусламж /дотоод/	1,249,900,300.00	1,222,016,354.00	27,883,946.32	97.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,401,780,300.00	1,313,674,141.98	88,106,158.02	93.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,401,780,300.00	1,313,674,141.98	88,106,158.02	93.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,264,532,300.00	1,224,783,654.80	39,748,645.20	96.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	901,250,700.00	891,939,173.30	9,311,526.70	99.0
210101	Үндсэн цалин	454,581,400.00	471,605,252.80	-	103.7
210102	Нэмэгдэл	285,211,500.00	290,914,488.40	-5,702,988.40	102.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,734,800.00	29,280,000.00	5,454,800.00	84.3
210104	Урамшуулал	126,723,000.00	100,139,432.10	26,583,567.89	79.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,813,700.00	120,215,164.00	15,598,536.00	88.5
210201	Тэтгэврийн даатгал	96,858,600.00	89,052,564.00	7,806,036.00	91.9
210202	Тэтгэмжийн даатгал	9,739,100.00	7,791,000.00	1,948,100.00	80.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,869,200.00	3,895,200.00	974,000.00	80.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,869,200.00	3,895,200.00	974,000.00	80.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,477,600.00	15,581,200.00	3,896,400.00	80.0
2104	Хангамж, бараа материалын зардал	34,771,700.00	32,086,805.50	2,684,894.50	92.3
210401	Бичиг хэрэг	5,741,900.00	4,360,270.00	1,381,630.00	75.9
210402	Тээвэр, шатахуун	15,894,000.00	17,290,035.50	-1,396,035.50	108.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,133,100.00	2,820,000.00	1,313,100.00	68.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,762,400.00	4,270,900.00	1,491,500.00	74.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,240,300.00	3,345,600.00	-105,300.00	103.2
2105	Нормативт зардал	110,729,400.00	107,192,092.00	3,537,308.00	96.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,037,700.00	86,594,742.00	1,442,958.00	98.4
210502	Хоол, хүнс	19,241,700.00	17,235,650.00	2,006,050.00	89.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,450,000.00	3,361,700.00	88,300.00	97.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,837,000.00	33,633,800.00	4,203,200.00	88.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210602	Тавилга	6,000,000.00	5,085,000.00	915,000.00	84.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.00	3,903,600.00	96,400.00	97.6
210604	Урсгал засвар	24,837,000.00	21,645,200.00	3,191,800.00	87.1
2107	Томилолт, зочны зардал	2,500,300.00	2,496,600.00	3,700.00	99.9
210702	Дотоод албан томилолт	2,500,300.00	2,496,600.00	3,700.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,911,300.00	20,502,020.00	4,409,280.00	82.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,842,100.00	17,846,450.00	3,995,650.00	81.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	55,000.00	55,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	70,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	30,000.00	30,000.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,682,200.00	1,268,570.00	413,630.00	75.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,718,200.00	16,718,000.00	200.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,718,200.00	16,718,000.00	200.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,248,000.00	88,890,487.18	48,357,512.82	64.8

2132	Бусад урсгал шилжүүлэг	137,248,000.00	88,890,487.18	48,357,512.82	64.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	87,550,000.00	39,192,487.18	48,357,512.82	44.8
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	49,698,000.00	49,698,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			-	
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	0.00	168,146.70	-168,146.70	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	-168,146.70	168,146.70	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	0.00	-168,146.70	168,146.70	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	29.74	-29.74	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	168,176.44	-168,176.44	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	28	28		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1	1		
620001	Удирдах ажилтан	28	28		
620002	Гүйцэтгэх ажилтан	1	1		
620003	Үйлчлэх ажилтан	21	21		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6	6		

2.6 Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31,366,300.00	31,320,009.11	46,290.89	99.85
12	Татварын бус орлого	31,366,300.00	31,320,009.11	46,290.89	99.85
122	Тусламжийн орлого	31,366,300.00	31,320,009.11	46,290.89	99.85
122005	Төсвөөс санхүүжих	31,366,300.00	31,320,009.11	46,290.89	99.85
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,366,300.00	31,320,009.11	46,290.89	99.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,366,300.00	31,320,009.11	46,290.89	99.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,366,300.00	31,320,009.11	46,290.89	99.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,066,300.00	27,020,009.11	46,290.89	99.83
210301	Гэрэл, цахилгаан	5,117,800.00	5,320,009.11	-202,209.11	103.95
210302	Түлш, халаалт	21,948,500.00	21,700,000.00	248,500.00	98.87
2106	Эд хогшил урсгал засварын зардал	4,300,000.00	4,300,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	4,300,000	4,300,000	0	100
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	0	0		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	0		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	0	0		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 92.2 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчлийг илрүүлснээс залруулагдаагүй алдаа болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 92.2 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 92.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 17,671.4 мянган төгрөгөөс 17,579.2 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

“Монос Хөвсгөл” ХХК-тай 10,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч 39,231.8 мянган төгрөгийн худалдан авалт хийж гэрээний үнээс 29,231.8 мянган төгрөгөөр хэтрүүлж худалдан авалт хийсэн байна. Нэмэлт худалдан авалт хийхдээ худалдан авах ажиллагаа зарлаагүй, гэрээнд өөрчлөлт оруулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна:”, 40 дүгээр зүйлийн 40.2.1-т Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно: энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэж заасныг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 92.2 мянган төгрөгийг цалингийн бүлгээс шилжүүлж эдийн засгийн ангилал зөрүүлж гүйлгээ гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн "0" үлдэгдэлтэй 6 нэр төрлийн 40,960.0 мянган төгрөгийн 12 ширхэг хөрөнгө үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа нь "Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." заалтад нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

3. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 8 мөнгөн гүйлгээний 205,921.3 мянган төгрөгийн орлогыг хугацаа хоцроосон, "эм эмнэлэгийн хэрэгсэл, хоол хүнс, бусдаар гүйцэтгүүлэх зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардал"-ын таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг тухай бүр мэдээлэх байтал 45 удаагийн 42,493.6 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 7 шийдвэрийн 7,753.5 мянган төгрөгийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 заалт "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх";, 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5 заалт "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр";, 6.4.8 заалт "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;"заалтуудад нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж зөрчлийг арилгах.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Завсрын аудитаар илрүүлсэн зөрчлийн нэгтгэл								
Эмнэлэгийн эмч мэргэжилтэний өмсгөлийг зарлагдсан тул буцаан үнэ төлбөргүйгээр орлогод авч эд хөрөнгийн картанд бүртгэсэн байна.	1	1,040.0					1	1,040.0
Шатахууны зарлагыг тухай бүрт нь бүртгэлд тусгаагүй, улирлын дүнгээр бүртгэж байсан зөрчлийг арилгаж тухай бүрт нь орлого зарлагын гүйлгээг хийж мөрдсөн байна.	1	0					1	0
Завсрын аудитын дүн	2	1,040.0					2	1,040.0
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 92.2 мянган төгрөгийг цалингийн бүлгээс гаргасан.	1	92.2					1	92.2
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн "0" үлдэгдэлтэй 6 нэр төрлийн 40,960.0 мянган төгрөгийн 12 ширхэг хөрөнгө үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй	1	0,0					1	0,0
Жилийн эцсийн аудитын дүн	2	92.2					2	92.2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 8 мэдээлэл худалдан авалтын 45 удаагийн 42,493.6 мянган төгрөгийн мэдээлэл, төсөв хөрөнгө өмч хөрөнгө зарцуулах 7 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	0.00					1	0.00
Монос Хөвсгөл ХХК-иас эм, эмнэлэгийн хэрэгслэл 29,231.8 мянган төгрөгөөр хэтрүүлсэн худалдан авалт хийсэн	1	0.00			1	0.00		
Дүн	2	0.00			1	0.00	1	0.00

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			